



**МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 07 сарын 07 өдөр

Дугаар A/809

Мандалговь


Амжилт гаргасан тамирчид, багш дасгалжуулагч,  
ардын авьяастанд урамшуулалт олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4, аймгийн Засаг даргын 2022 оны A/88 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Урамшууллын жишиг тогтоох журам”-ын 1.2, 1.6, 1.7, 1.11, 3.2.2 дахь заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. 2022 оны эхний хагас жилд зохион байгуулагдсан Улсын аварга шалгаруулах урлаг, спортын тэмцээн, уралдаанд амжилттай оролцож, эхний гурван байранд шалгарсан тамирчдыг шагнаж урамшуулсугай.
2. Урамшууллын зардлыг хавсралтаар баталсугай.
3. Урамшуулалд олгох 10,485,000 ( Арван сая дөрвөн зуун наян таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МОНХБАТ



4822111073